



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

**“ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

**ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНЭЭС БУСАД ЗОРИУЛАЛТААР
ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ АСУУДЛЫГ ХУУЛИЙН ДАГУУ
ШИЙДВЭРЛЭЭГҮЙ БАЙГАА НЬ ТӨРӨӨС БАРИМТЛАХ
ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРЧИМ АЛДАГДАЖ БАЙНА.**

АУДИТЫН КОД: ДГА-2024/30-6-ШТА-ГА

2024 оны 10 дугаар сар

АГУУЛГА:

Товьёг	3
Товчилсон үгийн тайлбар	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5-6
1.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байгаа нь өмнөх онуудад төлөвлөлттэй холбоотой гарч байсан зөрчил буурах нөхцөлийг бүрдүүлж байна.	7-8
1.1.1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2018 онд шинэчлэгдэн батлагдсантай уялдуулан аймгийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж эхэлсэн байна.	8-9
1.1.2. Сумд газар зохион байгуулалтын 2023 оны жилийн төлөвлөгөөг батлагдсан аргачлал, чиглэлийг баримтлахгүй боловсруулснаас ихэнх сумд тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.....	9-11
1.2. Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг холбогдох аргачлал, чиглэлийн дагуу төлөвлөх шаардлагатай байна.	
1.2.1. Газар зохион байгуулалтын үндсэн баримт бичгүүдийн уялдаа, нийцлийг хангаж, тухайн жилийн төлөвлөгөөг төлөвлөх шаардлагатай байна.	11-14
1.2.2. Сумдын газар зохион байгуулалтын 2023 оны жилийн төлөвлөгөө 66.3 хувийн хэрэгжилттэй байна.	14-16
2.1. Газрыг хууль, журмын дагуу эзэмшүүлээгүй байгаа нь төрөөс газрын талаар баримтлах шударга ёс, тэгш байдлыг хангах зарчим хангагдахгүй байна.	
2.1.1. Тухайн жилийн төлөвлөгөөтэй уялдуулахгүй, хүчин төгөлдөр бус хууль, дүрэм журмын заалтыг үндэслэн газар эзэмшүүлсэн байна.	16-24
2.1.2. Аймгийн хэмжээнд ашиглалтгүй байгаа газрын судалгааг гаргаж, дахин төлөвлөлтөд оруулах шаардлагатай байна.	24-25
2.1.3 Газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой өргөдөл, хүсэлтийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр шийдвэрлэж эхэлсэн нь газрыг тэгш, хүртээмжтэй хуваарилах боломж бүрдсэн байна.	25-26
2.2. Хууль, журмын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын газар ашиглах эрхийг бүртгэх асуудлыг шийдсэнээр газрын төлбөрийн орлого нэмэгдэх боломж байна.	
2.2.1. Газар зөвшөөрөлгүй ашигласан, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид газар ашиглах эрхээ баталгаажуулахгүй байгаа зэрэг нь газрын төлбөрөөс орох орлогод нөлөөлж байна.	26-27
2.2.2. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө 85.9 хувийн хэрэгжилттэй байна.	27-29
3.1. Орон нутгийн удирдлагаас газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлсэн боловч авсан арга хэмжээ, өгсөн зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтийг нэгтгэх, үр дүнг дүгнэх ажил хангалтгүй байна.	
3.1.1. Газрын чиглэлээр хэрэгжүүлсэн хяналт шалгалтын үр дүнг нэгтгэж дүгнэсэн байдал тодорхойгүй байна.	29-30
3.1.2. Аймаг, сумдын ИТХ шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг бодит үр дүнд чиглүүлснээр төлөвлөлт сайжирч, зөрчил буурах боломж байна.	30-31
3.2. Сумдад даамлаар ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаа нь хяналт шалгалтын ажлын үр дүнд нөлөөлж байна.	
3.2.1. Аймгийн ГХБХБГ-аас хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа боловч газрын харилцаанд оролцогч талууд зөвлөмж чиглэлийг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас зөрчил давтагдаж байна.....	31-33
3.2.2. Аймгийн БОАЖГ нь Газрын тухай хууль, тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт шалгалтыг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.	33-34
Дүгнэлт	35-36
Зөвлөмж	37-39
Холбогдох байгууллагын санал:	

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

“Газрын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг хийн, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн ба зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн хангагдсан эсэх;
- Газар олгох шийдвэр, үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлж, төлбөр, хураамжийг бүрэн төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх;
- Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд холбогдох байгууллага албан тушаалтан хяналт тавьж, арга хэмжээ авсан эсэх.

Аудитад Газрын тухай хуулийн зорилго, зорилт, арга хэмжээг орон нутагт хариуцан хэрэгжүүлэгч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, сумдын Төсвийн төвлөрүүлэн захирагчид, Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймаг сумдын ИТХ, Засаг даргын тамгын газар, бусад холбогдох байгууллагуудыг хамруулж, 2023 оны мэдээ, тайлан, тоон өгөгдөл, бусад нотлох баримтад үндэслэж гүйцэтгэсэн.

Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит, Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, А/71 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан аудитад хамрагдах иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлж, ашиглуулах, өмчлүүлэх шийдвэр, үйл ажиллагаатай холбогдох шийдвэр, баримт материал, хувийн хэрэг, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашигласан аудитын дүн, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Э.Эрдэнэсүвд нар гүйцэтгэсэн.


Аудитын төлөвлөгөөг 2024.06.06-ны өдөр батлуулж, гүйцэтгэлийн үе шатыг 2024.06.07-ны өдрөөс 09.10-ны хугацаанд гүйцэтгэж, тайланг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр дуусгавар болгож, аудитын зөвлөлийн хурлаар 2024 оны 11 сард хэлэлцүүлэн дарга, тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлсэн.

1.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байгаа нь өмнөх онуудад төлөвлөлттэй холбоотой гарч байсан зөрчил буурах нөхцөлийг бүрдүүлж байна.

Газрын нэгдмэл сангийн 2023 оны жилийн эцсийн мэдээллээр Дорноговь аймгийн нийт газар нутаг 10,947,229.64 га, үүнээс хөдөө аж ахуйн газар 9,352,442.58 га /85.43%/, хот тосгон, бусад суурины газар газар 217,728.13 га /1.9%/, зам шугам сүлжээний газар 65,115.35 га /0.59%/, ойн сан бүхий газар 158,603.92 га /1.44%/, усан сан бүхий газар 27,765.5 га /0.25%/, улсын тусгай хэрэгцээний газар 1,125,574.51 га /10.28%-г тус тус эзэлж байна.

Дүрслэл№1

Газрын нэгдмэл сангийн тайлангийн 2023 оны жилийн эцсийн дүнг өмнөх оны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 8,616,090 га-аар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 6,458,230 га, зам шугам сүлжээний газар 2,112,910 га, ойн сан бүхий газар 44,540 га-



аар тус тус нэмэгдэн, усан сан бүхий газар болон улсын тусгай хэрэгцээний газрын хэмжээнд өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт №1 Газрын үндсэн ангиллын төрлийн мэдээлэл

Газрын үндсэн ангилал	Нийт хэмжээ /га/	Төрөл	Төрлийн дүн /га/	Ангилал д эзлэх хувь	Бэлчээрийн газраас бусад ангилалд шилжүүлсэн	Бусад газраас бэлчээрийн ангилалд шилжүүлсэн
Хөдөө аж ахуй	9,352,442.5	Бэлчээр	8,924,207.3	95.4	-8,616,090	+134,250
		Хадлан	112.0	0.0		
		Усалгаатай тариалан	795.4	0.0		
		Усалгаагүй тариалан	7.7	0.0		
		Атаршсан газар	329.3	0.0		
		ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр	6,658.6	0.1		
		ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	420,332.2	4.5		
Хот тосгон, бусад суурин	217,728.1	Барилга байгууламжийн газар	2,562.6	1.2	+135,840	
		Суурьшлын газар	3,496.2	1.6	+4,590	
		Үйлдвэрийн газар	9,422.2	4.3	+157,060	-5,250
		Нийтийн эдэлбэрийн газар	13,461.1	6.2		
		Аялал жуулчлалын газар	80.4	0.0		-1,800
		Уурхайн газар	188,705.6	86.7	+6,160,740	-124,550
		Төмөр замын газар	11,208.2	17.2	+2,900	-540

“Газрын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудит

Зам шугам сүлжээ	65,115.3	Авто зам	37,345.4	57.4	+1,771,620	
		Агаарын тээвэр	4,088.3	6.3		
		Шугам сүлжээ	12,473.4	19.2	+338,390	-2,110
Улсын тусгай хэрэгцээ	1,125,574.5	Улсын тусгай хамгаалалттай газар	792,142.0	70.4		
		Улсын хилийн зурвас	299,000.0	26.6		
		Чөлөөт бүсийн газар	900.0	0.1		
		Байгаль орчин, цаг агаарын ажиглалтын талбай	6,293.1	0.6		
		Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	23,400.0	2.1		
		Батлан хамгаалах зориулалт	1,071.2	0.1		
		Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	2,768.2	0.2		
		Ойн сан	158,603.9		0.0	+44,950
Усан сан	27,765.5		0.0			
ДҮН	10,947,229.6			8,616,090	134,250	

/Эх сурвалж: Газрын нэгдмэл сангийн 2023 оны жилийн тайлан/

Аймгийн хэмжээнд 2023 онд 1405 нэгж байршилд 1,507,267.17 га газрыг иргэн, ААНБ-ын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгосон байна.

1.1.1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2018 онд шинэчлэгдэн батлагдсантай уялдуулан аймгийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж эхэлсэн байна.

Дорноговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2016.12.05-ны өдрийн 03/06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан байна.

Монгол Улсын бодлогын баримт бичгүүд шинэчлэгдэн батлагдаж, хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт хийгдсэн, шинэ бодлого зорилт, бүсчилсэн хөгжлийн стратегийг орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, хэтийн төлөвтэй уялдуулж хэрэгжүүлэхтэй холбоотой аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын төсвийг ОНТХО-ын эх үүсвэрээс шийдвэрлэж, 2024.06.10-2025.04.30-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр Лапланд Эко ХХК-тай гэрээ байгуулж, тус ажил хэрэгжих шатандаа явж байгаа нь газар, байгалийн нөөцийг өнөөгийн бодит байдалд нийцүүлэн үр дүнтэй, зүй зохистой ашиглах боломж нэмэгдэх төдийгүй хуучин төлөвлөлтэй холбоотой үүсэж байсан газрын маргаан, зөрчил буурах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.1.2. Сумд газар зохион байгуулалтын 2023 оны жилийн төлөвлөгөөг батлагдсан аргачлал, чиглэлийг баримтлахгүй боловсруулснаас ихэнх сумд тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 “Сумын Засаг дарга газрын харилцааны талаар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэрийнхээ тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын ИТХ-д өргөн мэдүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу сумдын ИТХ-ын 2022 оны 08/04, 10/72, 11/04, 08/05, 08/45, 10/06, 12/09, 09/06, 11/06, 11/38, 11/27, 09/05, 11/05, 10/05 дугаар тогтоолуудаар 2023 оны газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг баталж, мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд байршуулсан байна.

/Хүснэгт№2/ **Сумдын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөлт**

№	Сумын нэр		
---	-----------	--	--

		Нийт нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/
1	Айраг	129	987.5
2	Алтанширээ	56	18,951.8
3	Даланжаргалан	195	1,462.6
4	Дэлгэрэх	20	31,375.4
5	Замын-Үүд	411	400.2
6	Иххэт	27	123,308.5
7	Мандах	28	814,752.0
8	Өргөн	25	25,734.4
9	Сайншанд	900	4,764.2
10	Сайхандулаан	55	479,720.5
11	Улаанбадрах	28	112.1
12	Хатанбулаг	110	449.0
13	Хөвсгөл	51	440.5
14	Эрдэнэ	83	61,857.4
	Нийт	2,118	1,564,315.8

ГХБГЗЗГ-ын даргын 2010 оны 497 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-д жилийн төлөвлөгөөг боловсруулахад баримтлах зарчим, шийдвэрлэх асуудал, төлөвлөгөө боловсруулах, баталгаажуулах дарааллыг тодорхой тусгаж баталсан байна.

Аймгийн ГХБХБГ-аас дээрх журмын 7.2-т заасан чиг үүргийн дагуу сумдын Засаг дарга нарт 2022.06.08-ны өдрийн 314 дугаар албан бичгээр 2023 оны газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахад анхаарах чиглэлийг хүргүүлсэн.

Гэтэл сумдууд газар зохион байгуулалтын 2023 оны жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа батлагдсан аргачлалд заасан арга зүй, баримтлах зарчим, боловсруулах дарааллыг мөрдөөгүй, шийдвэрлэх асуудлуудыг хөндөж баримтжуулсан байдал хангалтгүй байгаагаас Айраг/2/, Алтанширээ/2/, Даланжаргалан/2/, Дэлгэрэх/2/, Замын-Үүд/1/, Мандах/3/, Өргөн/2/, Сайншанд/2/, Сайхандулаан/2/, Хатанбулаг/2/, Эрдэнэ/1/ зэрэг 11 сум 2023 оны газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд нийт 21 удаагийн нэмэлт өөрчлөлтийг оруулж, 566 нэгж талбарын, 1,152.6 мянган га газрыг нэмж төлөвлөн батлуулсан байна.

1.2. Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг холбогдох аргачлал, чиглэлийн дагуу төлөвлөх шаардлагатай байна.

1.2.1. Газар зохион байгуулалтын үндсэн баримт бичгүүдийн уялдаа, нийцлийг хангаж, тухайн жилийн төлөвлөгөөг төлөвлөх шаардлагатай байна.

Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хот, тосгоны хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчин бүрдүүлэхэд чиглэгдсэн хот байгуулалтын үндсэн баримт бичиг гэж тодорхойлсон бөгөөд Хот байгуулалтын тухай хуулийн 8.1.5-д “*Аймаг, нийслэлийн ИТХ нь хот байгуулалтын талаар бүс нутгийн хөгжлийн төслийн үндсэн шийдэлтэй уялдуулан орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*” гэж заасан.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015.07.01-ний өдрийн 30 дугаар тогтоолоор 12 сум “Сумын хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г /2015-2025 он/ батлуулсан байх ба Даланжаргалан, Өргөн сумд одоог хүртэл боловсруулж батлуулаагүй байна.

Иргэн, ААНБ-д газар эзэмшүүлж, ашиглуулах үйл ажиллагааг хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхээр байхад 2023 онд олгогдсон газрууд нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ч хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдаагүй байна. Тухайлбал:

- Айраг сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зам талбай, орон сууцны зориулалтаар төлөвлөгдсөн бүсэд нийтийн эзэмшлийн талбайн зориулалтаар 2 нэгж талбарт, 1.7 га газар олгохоор жилийн төлөвлөгөөнд тусгасан.



Ерөнхий төлөвлөгөөнд шар өнгөөр тэмдэглэсэн бүс нь орон сууц, ногоон өнгөөр тэмдэглэсэн бүс нь ногоон байгууламж, улаан өнгөөр тэмдэглэсэн зам талбайн зориулалттай байхаар тусгасан байна.

- Замын-Үүд сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зам талбайн зориулалттай бүсэд 66 байршилд, 3.3 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, тусгай хэрэгцээний ногоон байгууламжийн зориулалттай бүсэд 3 байршилд 0.6 га газрыг худалдаа үйлчилгээний зориулалтаар олгохоор тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан.

(Зураг №3)

(Зураг №4)



Ерөнхий төлөвлөгөөнд хар саарлаар тэмдэглэсэн нь зам талбай, цайвар ногоон өнгөөр тэмдэглэсэн нь тусгай зориулалтын ногоон байгууламж, хар ногоон өнгөөр тэмдэглэсэн нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд гэр бүлийн зориулалтаар олгохоор тусгасан байна.

- Сайншанд сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зам талбайн бүсэд 2 байршилд 0.14 га, ногоон байгууламж, олон нийтийн зориулалттай бүсэд 54 байршилд, 3.4 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгохоор тус тус жилийн төлөвлөгөөнд тусгасан.

(Зураг №5)

(Зураг №6)

(Зураг №7)



Ерөнхий төлөвлөгөөнд ногоон өнгөөр тэмдэглэсэн бүс нь ногоон байгууламж, саарал өнгөөр тэмдэглэсэн зам талбайн бүс, хар ногоон өнгөөр тухайн жилийн төлөвлөгөөнд гэр бүлийн зориулалттай байхаар тусгасан байна.

- Хөвсгөл сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зам талбайн бүсэд 1 байршилд 0.04 га газрыг худалдаа үйлчилгээний зориулалтаар, нөөц газрын бүсэд 2 байршилд, 0.14 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгохоор тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан.

(Зураг №8)



(Зураг №9)



Ерөнхий төлөвлөгөөнд саарал өнгөөр зам талбай, цайвар ягаан өнгөөр нөөц газрыг тэмдэглэсэн, тод цэнхэр өнгөөр тухайн жилийн төлөвлөгөөнд гэр бүл, худалдаа үйлчилгээний зориулалтаар олгохоор төлөвлөсөн (Зураг №10)

- Эрдэнэ сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд амралт зугаалга, аялал жуулчлалын бүсэд 16 байршилд, 1.4 га газрыг, нөөц газрын бүсэд 20 байршилд, 1.8 га газар, нийт 36 байршлын 3.2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 32.4 га газар олгохоор тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан.



өнгөөр нөөц газрыг, цайвар ногоон өнгөөр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгохоор төлөвлөсөн газар байна.

(Зураг №11)

- Иххэт сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зам талбайн бүсэд 1 байршлын 0.2 га газрыг нийтийн эдэлбэр, цэцэрлэгт хүрээлэнгийн зориулалтаар төлөвлөсөн байна.

Ерөнхий төлөвлөгөөнд хар саарал өнгөөр тэмдэглэсэн нь зам талбайн бус, тод ногоон өнгөөр тэмдэглэсэн нийтийн эдэлбэр, цэцэрлэгт хүрээлэнгийн зориулалтаар олгохоор төлөвлөсөн байна.



- Өргөн, Даланжаргалан сумд хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлаагүйгээс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтэд үндэслэн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.

Сумд хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан байгаа ч газар зохион байгуулалтын үндсэн баримт бичиг болох аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн төлөвлөгөөг уялдуулж төлөвлөөгүйгээс зөрчил гарсан байна.

1.2.2. Сумдын газар зохион байгуулалтын 2023 оны жилийн төлөвлөгөө 66.3 хувийн хэрэгжилттэй байна.

Газрын тухай хуулийн 20.2.1-т заасан аймаг, сумын Засаг дарга газрын харилцааны талаарх нийтлэг бүрэн эрхийн хүрээнд 2023 онд нийт 2118 нэгж талбарт, 1,564.3 мянган га

“Газрын тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудит

газрыг иргэн, аж, ахуйн нэгжид өмчлөх, ашиглах, эзэмшүүлэхээр төлөвлөж, 1405 байршилд 1,507.3 га газрыг олгон, биелэлт 66.3 хувьтай хэрэгжсэн байна.

/Хүснэгт№3/ Сумдын газар зохион байгуулалтын 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Сумын нэр	Төлөвлөлт <i>/Тухайн жилийн төлөвлөгөө/</i>		Биелэлт		Биелэлтийн хувь <i>/Олгогдсон нэгж талбараар/</i>	Төлөвлөгдөөгүй	
		Нийт нэгж талбар	Газрын хэмжээ /га/	Нийт нэгж талбар	Газрын хэмжээ /га/		Иргэн, ААН-ийн тоо	Газрын хэмжээ /га/
1	Айраг	129	987.46	108	955.88	83.7		
2	Алтанширээ	56	18,951.75	38	18,950.56	67.9		
3	Даланжаргалан	195	1,462.57	114	1,457.02	58.5	1	1
4	Дэлгэрэх	20	31,375.39	6	62.31	30.0		
5	Иххэт	27	123,308.46	25	123,307.48	92.6		
6	Өргөн	25	25,734.36	21	25,623.89	84.0		
7	Мандах	28	81,475.2	20	794,373.87	71.4	2	403.6
8	Сайхандулаан	55	479,720.48	48	479,718.79	87.3		
9	Сайншанд	900	4,764.19	637	548.58	70.8		
10	Эрдэнэ	83	61,857.36	59	61,793.8	71.1		
11	Улаанбадрах	28	112.08	20	8.95	71.4		
12	Хатанбулаг	110	449.02	53	142.42	48.2	1	400.0
13	Хөвсгөл	51	440.48	46	207.03	90.2		
14	Замын Үүд	411	400.24	209	116.59	50.9		
Нийт		2118	1,564,315.84	1,405	1,507,267.17	66.3	4	804.6

Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг олгогдсон нэг талбарын хэмжээгээр авч үзэхэд нийт 2118 байршил төлөвлөснөөс 1405 нэгж талбарыг олгож, Дэлгэрэх сум 30 хувь, Хатанбулаг сум 48.2 хувь, Замын-Үүд сум 50.9 хувь, Даланжаргалан 58.5 хувиар тус тус хэрэгжүүлсэн байгаа нь аймгийн газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний нийт биелэлтийн дүнд нөлөөлсөн байна.

Тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт бүрэн хангагдаагүй шалтгааныг авч үзэхэд:

- Хатанбулаг сум 2023 оны төлөвлөгөөнд 43 байршилд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэхээр төлөвлөсөн боловч тус байршилд төлөвлөсөн жишиг гудамжийг барьж байгуулаагүйгээс төлөвлөсөн газрыг эзэмшүүлээгүй.
- Дэлгэрэх сум 2023 оны төлөвлөгөөнд 13 байршилд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэхээр төлөвлөсөн боловч тус байршилд төлөвлөсөн жишиг гудамж барьж байгуулаагүйгээс төлөвлөсөн газрыг эзэмшүүлээгүй.
- Даланжаргалан сум 2023 оны төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэхээр 108 байршил төлөвлөснөөс иргэдээс нийт 37 өргөдөл ирүүлснийг шийдвэрлэж, өмчлүүлсэн.
- Замын-Үүд сум 2023 оны төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэхээр 361 байршил төлөвлөснөөс ба сумын удирдлагаас баримталж байгаа гэр байрыг хашаажуулах бодлогын дагуу эзэмших газрыг хашаажуулсан 180 иргэний газрыг эзэмшүүлж, шийдвэрлэсэн байна.

Сумдын 2023 онд газар эзэмшүүлж, ашиглуулсан шийдвэрийг үзэхэд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 4 байршилд 804.6 га газрыг олгож Газрын тухай хуулийн 33.1.1¹ дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Мандах сумын Засаг даргын 2023.07.21-ний өдрийн А/108 дугаар захирамжаар V дугаар багийн нутаг дэвсгэрт дулаан, ус хангамж, ариутгах татуургын инженерийн шугам сүлжээний барилга байгууламж барихаар 3.6 га газрыг 15 жилийн хугацаатай сумын ЗДТГ-т эзэмшүүлсэн.

¹ энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөөт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана;

- Даланжаргалан сумын Засаг даргын 2023.08.22-ны өдрийн А/153 тоот захирамжаар тус сумын IV багийн нутаг дэвсгэрт байрших газар тариалангийн хоорондын зурвас дахь 1 га газрын зориулалтыг өөрчилж, Даяд ариутгал ХХК-д ачиж буулгах талбайн зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн байна. /2023.08.24-ний өдрийн А/159 захирамжаар хүчингүй болгосон/

2.1. Газрыг хууль, журмын дагуу эзэмшүүлээгүй байгаа нь төрөөс газрын талаар баримтлах шударга ёс, тэгш байдлыг баримтлах зарчим хангагдахгүй байна.

2.1.1. Тухайн жилийн төлөвлөгөөтэй уялдуулахгүй, хүчин төгөлдөр бус хууль, дүрэм журмын заалтыг үндэслэн газар эзэмшүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 2118 нэгж талбарт газар олгохоор төлөвлөснөөс тухайн шатны Засаг даргын шийдвэрээр 1405 байршилд газар эзэмшүүлж, ашиглуулахаар шийдвэрлэсэн байна.

/Хүснэгт№4/Сумдын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт /арга хэмжээний төрлөөр/

Д/д	Арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн нэгж талбарын тоо	Хэрэгсэн нэгж талбарын тоо	Шийдвэрийн тоо	Хэрэгжилтийн хувь
1	Дуудлага худалдаагаар олгох	163	92	102	62.5
2	Өргөдлийн дагуу олгох	1,845	1,233	1233	66.8
3	Төсөл сонгон шалгаруулалт	13	3	5	38.4
4	Нөхөн сэргээх, хамгаалах	29	17	17	58.6
5	Нийтийн эдэлбэр газрын төлөвлөлт	67	48	48	71.6
6	Газар чөлөөлөх	1	-	-	0
Дүн		2,118	1,405	1405	66.3

ДУУДЛАГА ХУДАЛДАА: Сумдын газар зохион байгуулалтын 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан худалдаа, бүх төрлийн үйлчилгээ, үйлдвэрлэл, орон сууцны зориулалтаар тусгагдсан 137 нэгж талбарт 190 удаагийн газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулснаас 92 дуудлага худалдаа амжилттай болж, 347.04 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлсэн байна.

Орон нутгийн орлогын 2023 оны төлөвлөгөөнд газрын дуудлага худалдааны орлого 37,516.0 сая төгрөгийг төлөвлөж, 4,201.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Сумдын газар зохион байгуулалтын 2023 оны тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан боловч дуудлага худалдаа зохион байгуулаагүй шууд эзэмшүүлсэн, байршил өөрчилсөн, зөвшөөрөлгүй эзэмшиж байсан газруудыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр эзэмшүүлэхдээ дуудлага худалдааны анхны болон суурь үнээр төлбөр ногдуулж, 2,262.7 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.



/Хүснэгт№5/ 2023 онд зохион байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны мэдээлэл

№	Сум	Дуудлага худалдаа явуулсан тоо		Эзэмшүүлсэн газрын хэмжээ /га/		Төсөвт орсон орлого /мян.төг/	
		2022 он	2023 он	2022 он	2023 он	2022 он	2023 он
1	Айраг	27	9	6,364.4	8,138.1	13,808.4	32,877.7
2	Алтанширээ	3	4	0.096	105,264.1	782.0	362,665.7
3	Даланжаргалан	21	9	53,370.8	5,681.8	881,083.1	38,420.7
4	Дэлгэрэх	1	1	0.007	0.4	24.02	2,600.0
5	Замын-Үүд	29	36	66,750.4	102,373.3	4,132,885.4	1,743,020.2
6	Иххэт	1	2	0.007	0.0	146.8	547.2
7	Мандах	4	6	0.0	8.5	0.0	55,004.2
8	Өргөн	10	4	3,566.9	4.5	22,464.1	12,200.0
9	Сайншанд	64	26	70,752.4	45,590.2	1,707,641.8	130,675.9
10	Сайхандулаан	1	4	0.003	14.0	69.2	911.5
11	Улаанбадрах	11	8	0.09	7,097.9	258.0	1,008.5
12	Хатанбулаг	76	64	196,725.9	44.1	13,509,513.6	1,814,362.6
13	Хөвсгөл	2	7	0.035	0.06	261.8	3,140.0
14	Эрдэнэ	17	10	13,810.2	1,342.1	100,694.2	4,166.3
Нийт		267	190	411,581.2	347,047.5	20,369,850.4	4,201,600.8

Дээрх мэдээллээс харахад Замын-Үүд, Сайншанд, Хатанбулаг сумдад 20-иос дээш удаа газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдаа зохион байгуулжээ.

/Дүрслэл№2/

/Дүрслэл№3/



Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг хэрэгжүүлсэн байдлыг авч үзэхэд дуудлага худалдаагаар газар эзэмшүүлсэн шийдвэртэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын I хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 11.2, 15.1 “Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг дуудлага худалдаа явуулах Ажлын хэсэг шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Хатанбулаг сумын III багийн нутаг дэвсгэрт байрлах 20 га газрыг чингэлэгт тээврийн терминалын зориулалттай газар эзэмшүүлэх дуудлага худалдаанд иргэн Б.Б ялагч болсныг сумын Засаг даргын 2022.09.13-ны өдрийн А/160 захирамжаар хүчингүй болгосон байна. Ялагч иргэн аймгийн ЗД-д гомдол гаргаж, сумын Засаг даргын 2023.08.21-ний өдрийн А/142 дугаар захирамжаар эзэмшүүлж шийдвэрлэсэн.
- Аймгийн ЗД-ын 2023 оны А/204 захирамжаар 2023.04.21-ний өдөр зохион байгуулагдсан газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн #2023-13277 дугаартай цахим дуудлага худалдаанд гомдол гаргаж, ГЗБГЗЗГ-аас аймгийн ГХБХБГ-т 2023.06.15-ны өдөр 23/17 дугаартай албан бичгээр серверт ямар нэгэн алдаа гараагүй, хэвийн ажилласан талаар мэдэгдлийг албан тоотоор хүргүүлсэн боловч тус асуудлыг өнөөдрийг хүртэл шийдвэрлээгүй байна.

2. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэх тухай заалтыг зөрчсөн зөрчлийг ГХБХБГ-ын 2022 оны 300 тоот албан бичгээр чиглэл хүргүүлж, шийдвэрийг хүчингүй болгуулсан байна.

- Хатанбулаг сумын ЗД-ын 2022.11.21-ний өдрийн А/199 захирамжаар сумын газар зохион байгуулалтын 2022 оны жилийн төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр тусгасан 160 га газрыг нэр бүхий 9 аж ахуйн нэгжид дуудлага худалдаа зохион байгуулахгүй эзэмшүүлсэн./Тус захирамжийг 2023.10.17-ны А/180 захирамжаар газар эзэмших эрхийг цуцалсан/
- Хатанбулаг сумын ЗД-ын 2022.12.19-ний А/223 захирамжаар сумын газар зохион байгуулалтын 2022 оны жилийн төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр тусгасан 20 га газрыг Сүмбэрэл хангал транс ХХК-д чингэлэгт тээврийн терминалын зориулалтаар, дуудлага худалдаа зохион байгуулахгүй эзэмшүүлсэн./Тус захирамжийг 2023.10.17-ны А/180 захирамжаар газар эзэмших эрхийг цуцалсан/
- Хатанбулаг сумын ЗД-ын 2023.11.01-ний А/189 захирамжаар Ханги боомтын суурьшлын бүсэд 2 га газрыг Мон лаа ХХК-д шатахуун түгээх станцын зориулалтаар дуудлага худалдаа зохион байгуулахгүй эзэмшүүлсэн./Тус захирамжийг 2024.01.12-ны өдрийн А/06 захирамжаар газар эзэмших эрхийг цуцалсан/

3. Монгол Улсын болон орон нутгийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах газрыг эзэмшүүлж шийдвэрлэсэн байна.

- Аймгийн ЗД-ын 2023.08.15-ны А/589 захирамжаар Сайншанд сумын 2023 оны жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд төлөвлөсөн 0,0849 га газрыг МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”, “Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасны дагуу төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, нутгийн брэнд бүтээгдэхүүнийг жуулчдад сурталчлах арга хэмжээний хүрээнд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Дорноговь аймаг дахь салбарт худалдаа үйлчилгээний цогцолборын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн газарт барьсан барилгын байршил нь олгогдсон байршлаас зөрүүтэй байна.

/Зураг№12/



- МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Хүнсний хангамж аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөн”-ий хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн ЗД-ын 2023.08.15-ны өдрийн А/590 захирамжаар Сайншанд сумын 2023 оны жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборын зориулалтаар төлөвлөсөн 5 га газрыг Суман зурхай ХХК-д эзэмшүүлсэн байна.

4. Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах байдалд хуульд заасан эрх бүхий албан тушаалтнууд үр дүнтэй хяналт шалгалт хийж, хууль, журмын дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйгээс өмнө эзэмшүүлсэн байршлын хэмжээг томсгож, зөвшөөрөлгүй ашиглаж байсан дараах газрыг эзэмшүүлсэн байна.

- Аринакомпьютерс ХХК-ний байршлыг сунган зөвшөөрөлгүй ашиглаж байсан Сайншанд сумын VI багийн Шинэ зууны 2-200 хаягт байрлах 0.0247 га газрыг сумын 2023 оны тухайн жилийн төлөвлөгөөнд үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэхээр тусгаж, дуудлага худалдааны суурь үнэ 3.9 сая төгрөгийг төлүүлэн, сумын ЗД-ын 2023.05.19-ний А/143 захирамжаар 25 жилийн хугацаатай эзэмшүүлсэн.

- Тэс петролиум ХХК-ний шатах тослох материал, түгээгүүрийн газар, агуулахын зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглаж байсан 0.6613 га газрыг Аймгийн ЗД-ын 2023.11.13-ны А/790 захирамжаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн байна.

Улс, орон нутгийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг холбогдох журмын дагуу төсөл сонгон шалгаруулах зарчмаар төлөвлөж шийдвэрлэх нь зарим иргэн, аж ахуйн нэгжид давуу байдал олгохгүй байх боломж байна.

ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ: МУ-ын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын II хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах

төсөл сонгон шалгаруулах журам”-ын 3.1, 3.2 дахь заалтад газрыг төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлж, ашиглуулах шаардлага, нөхцөлийг тус тус заасан.

Даланжаргалан, Хатанбулаг сумдад 2023 онд нийт 4 удаагийн газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 3 төсөл шалгарч, Мак цемент ХХК, Агаруут ханги хөгжил ХХК-иудад 15 жилийн хугацаатай газар эзэмшүүлж шийдвэрлэсэн байна.

/Хүснэгт№6/ 2023 оны газрын төсөл сонгон шалгаруулалтын мэдээлэл

Д/д	Сумын нэр	Байршил	Хэм жээ /га/	Ашиглалтын зориулалт	Өмчлөх, ашиглах, эзэмших	Эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа	Зохион байгуулсан огноо	Шалгарсан хуулийн этгээд
1	Даланжаргалан	4-р баг Хэрсэнгийн тойрмын зүүн талд	25	Нийтийн зориулалттай орон сууцны хороолол барих газар	Эзэмших	15	4/16/2023	Мак цемент ХХК
2	Хатанбулаг	3-р баг Ханги боомтын ойролцоо	50	Автомашини зогсоол	Эзэмших	15	12/28/2023	Эм Эл Талбай ХХК
3	Хатанбулаг	3-р баг Ханги боомтын ойролцоо	15.0	Уул уурхайн тэсрэх дэлбэрэх бодисын агуулах	Эзэмших	15	12/28/2023	Шаардлага хангаагүй
4	Хатанбулаг	3-р баг Ханги боомтын ойролцоо	7.1	Үйлдвэрийн болон дэд бүтцийн барилга байгууламж барих газар	Эзэмших	15	12/28/2023	Агаруут ханги хөгжил ХХК

/Эх сурвалж: ГХБХБГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан/

Газар эзэмших, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах газрын зориулалт нь батлагдсан журамд заасан зориулалттай нийцээгүй, тухайлбал УТХО-аар эсхүл гадаад улс, ОУБ-ын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, малчдын хоршоонд МАА-н үйлдвэрлэл эрхлэхэд зориулж эзэмшүүлэхээр байхад нийтийн зориулалттай орон сууцны хороолол барих, автомашины зогсоол, уул уурхайн тэсрэх дэлбэрэх бодисын агуулах, үйлдвэрийн болон дэд бүтцийн барилга байгууламж барих гэсэн зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтыг төлөвлөн зохион байгуулсан байна.

2023 онд зохион байгуулсан төсөл сонгон шалгаруулалтаас орон нутгийн орлогод Мак цемент ХХК, Агаруут ханги хөгжил ХХК-иуд журамд заасан хугацаанд 278.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, Эм Эл Талбай ХХК төсөл сонгон шалгаруулалтаар шалгарсан боловч гэрээ байгуулаагүй байна.

ГАЗРЫН БАЙРШИЛ ӨӨРЧИЛЖ ЭЗЭМШҮҮЛСЭН: ГХБГЗЗГ-ын даргын 2010 оны 497 дугаар тушаалаар батлагдсан “Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 6-д заасан шийдвэрлэх асуудлууд, ГЗБГЗЗГ-ын даргын 2021 оны 187 “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.9 дэх заалтыг зөрчиж Алтанширээ/1/, Даланжаргалан/2/, Замын-Үүд/1/, Сайншанд/6/, Хатанбулаг/2/, Хөвсгөл/3/ сумдын Засаг даргын захирамжаар 15 талбар нэгжид олгосон газрын байршлыг өөрчилсөн шийдвэр гаргасан байна. Тухайлбал:

- Менеж транс ложистик ХХК нь Хатанбулаг сумын III багийн нутаг дэвсгэр, 4408006547 нэгж талбарын дугаартай барилга, байгууламжийн зориулалттай 2 га газрыг 2022 оны А/222 захирамжаар сумын ЗД-ын 2023.12.26-ны А/218 захирамжаар байршил шилжүүлэн эзэмшүүлсэн.
- Иргэн Ш.О-ийн 4408006604 нэгж талбарын дугаартай шатахуун түгээх станцын зориулалттай газрыг Хатанбулаг сумын ЗД-ын 2023.05.11-ний А/101 захирамжаар байршил өөрчилсөн.
- Замын-Үүд сумын ЗД-ын 2023.10.27-ны А/287 захирамжаар иргэн Ч.Я-ын гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байсан 4401013239 нэгж талбарын дугаартай газрыг үйлчилгээний барилга барих гэсэн хүсэлтийг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газрын хэмжээг сунгаж эзэмшүүлсэн.

- Сайншанд сумын ЗД-ын 2023.10.02-ны А/278 захирамжаар иргэн П.Г, Г.Ц нарын гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар эзэмшсэн газрыг дэд бүтэц шийдэгдээгүй газар олгогдсон гэсэн шалтгаанаар байршил өөрчилсөн.
- Сайншанд сумын ЗД-ын 2023.07.26-ны А/545 захирамжаар иргэн Ц.Г, Г.М нарын IV багийн Өлзийт-Ухаа-3-15, 16 тоотод байрлах гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалттай газрыг байгалийн элэгдэлд орсон, суурьших боломжгүй гэсэн хүсэлтийг байршил өөрчилж шийдвэрлэсэн байна.

Өмнө онуудын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд дэд бүтцийн асуудлыг шийдвэрлээгүй байршлыг тусгаж газар эзэмшүүлж, өмчлүүлсэн нь Газрын тухай хуульд заасан эзэмшил газрын хэмжээ, байршил өөрчлөх шаардлагад нийцэхгүй шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Эрдэнэ сумын ИТХ-ын хурлын 2023.07.07-ны “Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 12/05 тогтоолын хавсралтаар батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 15 байршилд эзэмшүүлэх газрын төлөвлөлтийн нэгж талбарыг тусгаагүй, цахим мэдээллийн санд мэдээллийг бүртгээгүй, мөн Менеж транс ложистик ХХК-ний авто тээврийн үйлчилгээний барилга, байгууламжийн зориулалтаар эзэмшил газрын байршил шилжүүлэх хүсэлтийг Хатанбулаг сумын ИТХ-ын 2023.09.29-ний “Сумын газар зохион байгуулалтын 2023 оны жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 15/04 тогтоолд худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолборын зориулалтаар олгохоор зөрүүтэй тусгаж баталсан байна.

Энэ нь ГЗБГЗГ-ын даргын 2020 оны А/40 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам”-ын 7.1.5 дахь заалтыг зөрчсөн төдийгүй газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээний төрлийг буруу оруулсан нь төлөвлөгөөний хэрэгжилтийг/сумын Засаг даргын газар олгосон шийдвэр/ газрын кадастрын мэдээллийн санд хөрвөж, мэдээлэл бүрэн оруулах байдалд нөлөөлсөн байна.

Засгийн газрын 2022 оны 432 тогтоолын хавсралтаар батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүйгээс газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээс сумдын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой мэдээлэл авах, тодруулах, тулгах явцад сумдын газрын даамлууд мэдээллийн санд өгөгдөл, мэдээллийг бүрэн оруулаагүй, зарим мэдээллийн төлөв, ангиллыг буруу сонгосон байгаа нь газар зохион байгуулалт, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих мэдээллийн цахим санг бий болгох гол зорилт хангагдахгүй байх, мөн аймгийн газрын нэгдмэл сангийн тайлангийн үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх нөхцөл үүсэж байна.

Аймаг, сумдын ЗД нар газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбоотой шийдвэрийг хүчингүй болсон эрх зүйн акт, асуудалтай холбоогүй заалтыг үндэслэсэн, газрын нэгж талбарыг зөрүүтэй, давхардуулсан, хавсралтын мэдээлэл зөрүүтэй 19 шийдвэрийг баталсан байна. /Хавсралт№1/

Мөн МУ-ын ЗГ-ын 2022 оны 108 дугаар тогтоолоор Зүүн баян-Ханги чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл болон барилгын ажлын зөвшөөрлийг Монголиан транс лайн ХХК-д 5 жилийн хугацаатай олгож, холбогдох зөвшөөрөл, техникийн нөхцлийг зохих журмын дагуу шуурхай олгож ажиллахыг Дорноговь аймгийн Засаг даргад үүрэг болгосон. Тус тогтоолыг үндэслэн Мандах, Хатанбулаг сумын Засаг дарга нар Монголиан транс лайн ХХК-д нийт 800 га газрыг 25 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэснийг аймгийн ГХБХБГ-аас 2023.06 сард ЗГ-ын 108 дугаар тогтоол, ХХЕГ-аас олгосон зөвшөөрлийг үндэслэн тухайн төсөл хэрэгжүүлэгчид газар ашиглах зөвшөөрөл олгох чиглэлийг хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл шийдвэрлээгүй байна.

- Мандах сумын ЗД-ын 2023.05.05-ны 64 тоот захирамжаар Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын дэд бүтцийн барилга байгууламж барих инженерийн байгууламж, эрчим хүч, ус хангамж, бусад барилга байгууламж барихад шаардагдах 400 га газрыг Монголиан транслайн ХХК-д 25 жилийн хугацаатай эзэмшүүлсэн. /2023.07.17-ны өдрийн А/106 захирамжаар хүчингүй болгосон/
- Хатанбулаг сумын ЗД-ын 2023.05.05-ны А/96 тоот захирамжаар Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын дэд бүтцийн барилга байгууламжийг барих инженерийн

байгууламж, эрчим хүч, ус хангамж, бусад барилга байгууламж барихад шаардагдах 400 га газрыг Монголиан транслиан ХХК-д 25 жилийн хугацаатай эзэмшүүлсэн байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3-т заасан тухайн захиргааны байгууллагын чиг үүрэгт үл хамаарах асуудлаар захиргааны акт гаргасан тул Хатанбулаг сумын ЗД-ын А/96 захирамжийг хүчингүй болгож, ашиглах эрхийг шийдвэрлүүлэх тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Газрын харилцааны талаар шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнууд газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх захирамжлалын бичиг баримтыг зохих журмын дагуу, эрх зүйн үндэслэлтэй боловсруулж, батлах шаардлагатай байна.

2.1.2. Аймгийн хэмжээнд ашиглалтгүй байгаа газрын судалгааг гаргаж, дахин төлөвлөлтөд оруулах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 13 нэгж талбарын зориулалтыг өөрчилж, тухайн шатны Засаг даргын захирамжаар газар эзэмших эрхийн гэрчилгээг шинээр олгосон байна.

/Хүснэгт№7/ Газрын зориулалт өөрчилсөн иргэн, ААНБ-ын судалгаа

№	Сумын нэр	Газар эзэмшигч ААНБ	Газрын хэмжээ /га/	Газрын зориулалт		Захирамжийн огноо, дугаар
				Хуучин	Шинэ	
1	Хатанбулаг	Тахилт хайрхан трасс ХХК	0.51	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	Шатах, тослох материал түгээгүүрийн газар, агуулах, ШТС	Сумын ЗД-ын 2023.05.09 А/100
2	Хатанбулаг	Менеж транс ложистик ХХК	2	Барилга байгууламжийн бусад газар	Авто тээврийн үйлчилгээний зориулалтын барилга, байгууламж	Сумын ЗД-ын 2023.12.26 А/218
3	Замын-Үүд	Чин засагт ХХК	20	Агуулах	Ачилт буулгалтын талбай	Аймгийн ЗД-ын 2023.05.03 А/288
4	Замын-Үүд	Ч.Янжиндулам	0.08	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар	Худалдаа, үйлчилгээний зориулалт	Сумын ЗД-ын 2023.10.27 А/286
5	Замын-Үүд	Ч.Янжиндулам	70	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар	Худалдаа, үйлчилгээний зориулалт	Сумын ЗД-ын 2023.10.27 А/287
6	Сайншанд	Ө.Хишигдалай ЗИ89092615	0.05	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар	Худалдаа, үйлчилгээний зориулалт	Сумын ЗД-ын 2023.02.17 А/46
7	Сайншанд	Б.Итгэлт ЕЭ91092111	0.04	Орон сууц	Үйлчилгээтэй, орон сууцны зориулалт	Сумын ЗД-ын 2023.04.12 А/96
8	Сайншанд	С.Отгонцэцэг ЕЭ74112460	0.01	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар	Худалдаа, үйлчилгээний зориулалт	Сумын ЗД-ын 2023.10.25 А/295
9	Сайншанд	Б.Одгариг ЕЭ69032974	0.008	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар	Худалдаа, үйлчилгээний зориулалт	Сумын ЗД-ын 2023.10.25 А/296
10	Сайншанд	У.Ганзориг ЕЮ82033011	0.08	Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар	Худалдаа, үйлчилгээний зориулалт	Сумын ЗД-ын 2023.11.28 А/332
11	Сайншанд	Монгол банк 5465176	0.18	Банк санхүү	Төрийн байгууллага	Сумын ЗД-ын 2023.12.19 А/362
12	Сайншанд	П.Дажулав ЙЭ80052619	0.05	Гэр, орон сууцны хашааны газар	Худалдаа, үйлчилгээний зориулалт	Сумын ЗД-ын 2023.12.19 А/363
13	Сайншанд	Э.Мандахбаяр ЕТ87101639	0.012	Авто гараж	Нийтийн орон сууц	Аймгийн ЗД-ын 2023.07.26 А/547
Дүн			93.01			

Газрын тухай хуулийн 40.1.6 дахь заалтын дагуу газрыг зориулалтаар 2 жил дараалан үйл ажиллагаа явуулаагүй үндэслэлээр 149 иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтын газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, 1100 айлын орон

сууц, 960 суудалтай ерөнхий боловсролын сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг барих 16.7 га газрыг чөлөөлж, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн байна.

Замын-Үүд, Сайншанд сумдын газрын эзэмшилт, ашиглалтын байдлыг үзэхэд нийт 37 нэгж талбарын газрыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сүүлийн 2 жилийн хугацаанд ашиглаагүй байсан ба аймгийн хэмжээнд 2 жил ашиглаагүй газрын нэгдсэн судалгааг гаргаж, хууль тогтоомжид заасны дагуу тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай албан шаардлагыг сумдын ЗД нарт хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2.1.3 Газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой өргөдөл, хүсэлтийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр шийдвэрлэж эхэлсэн нь газрыг тэгш, хүртээмжтэй хуваарилах боломж бүрдсэн байна.

Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэнтэй холбогдуулан тухайн жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд олон нийтийн саналыг авах, төлөвлөх болон батлагдсан төлөвлөгөөг мэдээлэх, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох асуудлыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан шийдвэрлэх, цаасаар өргөдөл хүлээн авч шийдвэрлэхгүй байх, тус тогтоолыг хэрэгжүүлэхэд бүх талын оролцоо дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээлэл хүргүүлэн ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосны дагуу цахим системд бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдээс 31 чиглэлээр, нийт 3891 хүсэлтийг аймаг, сумдын ЗД нар холбогдох журмын дагуу шийдвэрлэсэн байна.

Аймгийн ГХБХБГ-г иргэд, ААНБ-аас нийт 161 өргөдөл ирүүлснээс 1 хуулийн этгээдийн өргөдлийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй байна. Тус асуудалтай холбоотой зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр тайлангийн 2.1.1 дэх хэсэгт тусгасан болно

2.2. Хууль, журмын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын газар ашиглах эрхийг бүртгэх асуудлыг шийдсэнээр газрын төлбөрийн орлого нэмэгдэх боломж байна.

2.2.1. Газар зөвшөөрөлгүй ашигласан, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид газар ашиглах эрхээ баталгаажуулахгүй байгаа зэрэг нь газрын төлбөрөөс орох орлогод нөлөөлж байна.

Газрын улсын бүртгэлээр 2023 онд 3,069 иргэн, 2,200 ААНБ-ын эзэмшиж, ашиглаж байгаа газраас 5,766.0 сая төгрөгийн газрын төлбөрийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр баталсан байна.

/Хүснэгт№8 /Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө/сумдаар/

№	Сумын нэр	Газрын төлбөрийн төлөвлөгөө (мян.төг)	Нийт төлбөр төлөгчийн тоо	
			Иргэн	Хуулийн этгээд
1	Айраг	82,931.0	869	145
2	Алтанширээ	702,625.4	553	124
3	Даланжаргалан	1,811,190.9	679	288
4	Дэлгэрэх	32,986.1	700	90
5	Замын-Үүд	1,091,360.3	3420	286
6	Иххэт	77,116.6	443	83
7	Мандах	300,185.0	363	79
8	Өргөн	272,998.1	509	181
9	Сайншанд	819,667.3	3115	486
10	Сайхандулаан	77,922.6	451	56
11	Улаанбадрах	176,017.4	240	59
12	Хатанбулаг	226,120.6	631	170
13	Хөвсгөл	69,184.2	480	63
14	Эрдэнэ	25,789.5	616	90
ДҮН		5,766,095.0	3,069	2,200

Аудитын хамрах хугацаанд нийт 4 аж ахуйн нэгж байгууллагад 3,956.47 га талбайд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байх

боловч зөвшөөрөл эзэмшигч компаниуд хууль, журмын дагуу холбогдох албан тушаалтанд ашиглах эрхийг баталгаажуулах хүсэлт гаргаж, баталгаажуулаагүйгээс газрын төлбөрийн орлогыг төлөвлөх нөхцөл бүрдээгүй байна.

2.2.2. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө 85.9 хувийн хэрэгжилттэй байна.

2023 онд газрын төлбөрийн орлогыг 5,766.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс, 13,069 иргэн, 2,200 ААНБ-ын эзэмшиж, ашиглаж байгаа газарт 7,421.2 сая төгрөгийн төлбөрийг ногдуулж, 4,956.2 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэн, орлогын төлөвлөгөө 85.9 хувьтай хэрэгжсэн байна.

Газрын төлбөрийн 2023 онд батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг сумдаар авч үзвэл Айраг, Дэлгэрэх, Замын-Үүд, Мандах, Сайхандулаан, Хатанбулаг, Хөвсгөл сумд 100-240 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, Алтанширээ, Иххэт, Өргөн, Улаанбадрах, Эрдэнэ сумдын биелэлт 77-92.9 хувьтай, харин Даланжаргалан, Сайншанд сумдын орлогын төлөвлөгөө 48-60 хувьтай биелүүлж, төлөвлөгөө тасарсан байна.

/Хүснэгт№9/ Газрын төлбөрийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт /сумаар/

№	Сумын нэр	Газрын төлбөрийн төлөвлөгөө (мян.төг)	Төлбөл зохих нийт төлбөр /мян.төг/	2023 онд төлсөн төлбөр (мян.төг)	Төлөгдөөгүй газрын төлбөрийн үлдэгдэл (мян.төг)	Хэрэгжилтийн хувь
1	Айраг	82,931.0	138,112.4	99,156.8	38,955.6	119.6
2	Алтанширээ	702,625.4	738,253.1	592,281.4	145,971.8	84.3
3	Даланжаргалан	1,811,190.9	2,068,273.0	1,088,079.8	980,193.1	60.1
4	Дэлгэрэх	32,986.1	105,098.6	35,826.0	69,272.6	108.6
5	Замын-Үүд	1,091,360.3	1,328,998.2	1,150,565.4	178,432.8	105.4
6	Иххэт	77,116.6	177,852.5	68,637.2	109,215.3	89.0
7	Мандах	300,185.0	533,562.1	374,166.4	159,395.7	124.6
8	Өргөн	272,998.1	278,959.1	237,059.4	41,899.7	86.8
9	Сайншанд	819,667.3	732,863.4	399,452.5	333,411.0	48.7
10	Сайхандулаан	77,922.6	427,166.1	187,284.9	239,881.1	240.3
11	Улаанбадрах	176,017.4	177,713.5	163,523.5	14,190.0	92.9
12	Хатанбулаг	226,120.6	611,041.6	469,817.4	141,224.2	207.8
13	Хөвсгөл	69,184.2	74,473.0	70,283.9	4,189.1	101.6
14	Эрдэнэ	25,789.5	28,859.7	20,049.2	8,810.4	77.7
	ДҮН	5,766,095.0	7,421,226.3	4,956,183.8	2,465,042.4	85.9

Газрын төлбөрийн нийт орлогын төлөгдөөгүй үлдэгдлийн 66.8 хувь нь уул уурхайн чиглэлээр ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй холбоотой байх ба тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүд тухайн сумын удирдлагад хулийн дагуу хүсэлт гаргаж газар ашиглах эрхээ баталгаажуулаагүй, мөн Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрлийг цуцлах шалгуур, үндэслэлд төлбөр хураамжийг бүрэн төлөхтэй холбоотой асуудал тусгагдаагүйгээс ААНБ-ууд ногдуулсан газрын төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулахгүй байх зөрчил арилахгүй байна.

Дорноговь аймагт 2023 оны жилийн эцсийн байдлаар 214 ААНБ-д 274,591.1 га газарт 2025-2052 он дуусах хугацаанд ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл олгогдсон ба аудитаар газрын улсын бүртгэлийг ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл олгогдсон ААНБ-ын жагсаалттай тулгахад 44 ААНБ-ын 113,061.3 га газрын ашиглах эрхийг баталгаажуулаагүй байна.

3.1.Орон нутгийн удирдлагаас газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлсэн боловч авсан арга хэмжээ, өгсөн зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтийг нэгтгэх, үр дүнг дүгнэх ажил хангалтгүй байна.

3.1.1. Газрын чиглэлээр хэрэгжүүлсэн хяналт шалгалтын үр дүнг нэгтгэж дүгнэсэн байдал тодорхойгүй байна.

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т заасан хяналт тавих чиг үүргийн дагуу аймаг, сумдын ЗД нар нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж, ЗГ, харьяалах дээд шатны ЗД-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлын үр дүнг тооцохтой холбоотой

мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт хэрэгжүүлсэн байгаа ч хяналтын үр дүн, хэрэгжилтийг нэгтгэж дүгнээгүй, хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэх тухай арга хэмжээг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой зорилт болгож тусгаагүй байна.

3.1.2. Аймаг, сумдын ИТХ шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг бодит үр дүнд чиглүүлснээр төлөвлөлт сайжирч, зөрчил буурах боломж байна.

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-т заасан аймаг, сумдын ИТХ-ын төрийн хяналт тавих эрхийн дагуу аймаг, сумдын ИТХ 2023 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг баталж, газрын харилцааны чиглэлээр баталсан тогтоолын хэрэгжилтийг хянаж, сум, аймгийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тоон үзүүлэлтээр харьцуулан дүгнэсэн боловч, ЗД-ын газар эзэмшүүлж, ашиглуулах тухай шийдвэрүүдийг баталсан төлөвлөгөөтэй уялдуулж, үндэслэлтэй шийдвэрлэсэн байдал, төлөвлөгөөнд тусгаадаагүй байршилд газар эзэмшүүлсэн зэрэг зөрчилтэй асуудлыг хэлэлцэж, бодит хэрэгжилтийг үнэлээгүй байгаа нь шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих арга хэмжээний үр дүн хангаадаагүй байна.

3.2. Сумдад даамлаар ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаа нь хяналт шалгалтын ажлын үр дүнд нөлөөлж байна.

3.2.1. Аймгийн ГХБХБГ-аас хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа боловч газрын харилцаанд оролцогч талууд зөвлөмж, чиглэлийг бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас зөрчил давтагдаж байна.

Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3-т заасан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналт тавих эрх хэмжээний хүрээнд ГХБХБГ нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтыг тусгаж, газар, геодези зураг зүйн хяналтын улсын ахлах байцаагч нийт 24 удаагийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 731 зөрчил илрүүлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна.

/Дүрслэл№4/



Илэрсэн зөрчлийг ангиллаар нь авч үзэхэд нийт зөрчлийн 40.8 хувийг эзэмших, ашиглах газрыг хүндэтгэх шалтгаангүй 2 жил дараалан ашиглаагүй, 36.1 хувийг газрын төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, 16.1 хувийг газар эзэмших эрхийн хугацаа дууссан зөрчил эзэлж, харин зөвшөөрөлгүй болон зориулалт бусаар газар ашигласан зөрчил 1.8 хувийг эзэлж байна.

Газар, геодези зураг зүйн хяналтын улсын ахлах байцаагчийн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн дүнд үндэслэн дийлэнх хувийг эзэлж байгаа зөрчлүүд, тухайлбал газрыг хүндэтгэх шалтгаангүй 2 жил дараалан ашиглаагүй, газрын төлбөрийг хугацаанд нь төлөөгүй, олгогдсон байршлаас зөрүүтэй газар эзэмшиж байгаа зэрэг зөрчлийг арилгах, мөн аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд нөлөөлөхүйц арга хэмжээг төлөвлөхөд чиглүүлж, үр дүнг үнэлэх шаардлагатай байна.

Сумдад ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, мөн аймгийн ГХБХБГ-аас өгсөн чиглэл, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас зөрчил буурахгүй байна.

3.2.2. Аймгийн БОАЖГ нь Газрын тухай хууль, тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт шалгалтыг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т заасан байгаль орчны болон ургамал, хорио цээр, эрүүл ахуй, геологи, уул уурхай зэрэг мэргэжлийн байгууллагын хяналт хэрэгжүүлэх эрхийн хүрээнд аймгийн БОАЖГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шалгалт хэрэгжүүлэх 7 арга хэмжээг тусган, аймгийн ИТХ, аймаг, сумдын ЗД, мэргэжлийн байгууллагуудтай хамтран зөрчил бууруулах арга хэмжээг авсан, мөн аймгийн ИТХ-аар тодорхой асуудлуудыг шийдвэрлүүлж, хэрэгжилтийг аймгийн ЗД, БОАЖЯ-д тайлагнасан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг батлагдсан аргачлалыг баримтлахгүй боловсруулснаас ихэнх сумд 1-3 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулж баталсан байна.
2. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулаагүй, мөн үе шатны хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулаагүйгээс аймгийн хэмжээнд нийт 167 нэгж байршилд, 12.7 га газрыг зориулалтын бус бүсэд төлөвлөж, эзэмшүүлсэн байна.
3. Өргөн, Даланжаргалан сумд газар зохион байгуулалтын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулаагүй байна.
4. Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 2 байршилд 4.6 га газрыг эзэмшүүлсэн байна.
5. Өмнөх онуудын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд дэд бүтцийн асуудлыг шийдвэрлээгүй байршлыг тусгаж газар эзэмшүүлж, өмчлүүлсэн нь Газрын тухай хуульд заасан эзэмшил газрын хэмжээ, байршил өөрчлөх шаардлагад нийцэхгүй шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
6. Дуудлага худалдааг үндэслэлгүй цуцалж, ялагчид газар эзэмшүүлэх асуудлыг холбогдох журмын дагуу шийдвэрлээгүй байна.
7. Улс, орон нутгийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой 3 байршилд 5.1 га газрыг эзэмшүүлсэн байна.
8. ААНБ-д 0.62 га газрыг дуудлага худалдааны суурь үнийг төлүүлэн эзэмшүүлсэн байна.
9. Батлагдсан журамд заасан үйл ажиллагааны төрөлд нийцээгүй төсөл сонгон шалгаруулалтыг төлөвлөж, 2 аж ахуйн нэгжид 32.1 га газрыг эзэмшүүлсэн байна.
10. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд 2023 оны газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулахтай холбоотой өгөгдөл, мэдээллийг бүрэн оруулаагүй байна.
11. Шийдвэрлэх асуудалтай холбоогүй, хүчингүй болсон эрх зүйн актыг үндэслэсэн захирамжаар 21 байршилд газар эзэмшүүлсэн байна.
12. Газрын төлбөрийн орлогыг 5,766.1 сая төгрөгөөр төлөвлөн, орон нутгийн орлогод 4,956.2 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 85.9 хувь байна.
13. Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд аймаг сумын ИТХ, Засаг дарга хяналт шалгалт хэрэгжүүлсэн боловч, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгож төлөвлөөгүй, хяналтын үр дүнг нэгтгэж дүгнээгүй байна.
14. Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд ГХБХБГ-аас хяналт шалгалт хэрэгжүүлсэн боловч хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн дүнд үндэслэн өндөр эрсдэлтэй байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулаагүй байна.

Аудитаар илрүүлсэн зөрчилд зөрчил арилгах тухай 5 албан шаардлага тогтоож, зөрчил давтан гаргахгүй байх тухай 13 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ САНАЛ УЛАМЖЛАХ НЬ:

Газрын төлбөрийн орлогын нийт төлөгдөөгүй үлдэгдлийн 66.8 хувь нь Дорноговь аймагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй холбоотой байна.

Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлнө”, 55.1 “Газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагаа нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна”, Газрын төлбөрийн тухай хуулийн 9.1 “Газрын төлбөрийг газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгээгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно” гэж тус тус заасан.

Гэтэл Ашигт малтмалын тухай хуульд ашиглалтын тусгай зөвшөөрөл нь ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичиг гэж тодорхойлсон ба хуулийн 9.1.11 дэх заалтад “Ашигт малтмалын асуудлаар Засгийн газар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хайгуулын болон энэ хуулийн 24.1-т зааснаас бусад тохиолдолд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайг солбицлоор тогтоож, нийтэд мэдээлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэсэн заалтын хүрээнд ашиглах эрхийг олгож, үйл ажиллагаа нь үргэлжлэн явагддаг, мөн тус хуулийн 55 дугаар зүйлд тусгасан тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэлд хуулийн этгээд нь газар ашиглах эрхийг орон нутгаар шийдвэрлүүлэх, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгүүлж үйл ажиллагааг эхлүүлэх, газрын төлбөрийг бүрэн төлж барагдуулах, орон нутагт төлбөрийн өглөггүй байх зэрэг тодорхой заалт тусгагдаагүй байна.

Орон нутгийн байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан чиг үүргийн дагуу газрын төлбөрийн орлогын ногдуулалт, төлөлтөд хяналт тавьж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч дээрх хуулиудын нийцэл хангагдахгүй байгаа, мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид ногдуулах хариуцлага тодорхой бус байгаагаас газрын төлбөрийн орлогыг бүрэн ногдуулах, өмнө онуудын авлага барагдуулах ажлын үр дүн гарахгүй, жил бүр зөрчил гарсаар байна.

Иймд дээрх хуулийн нийцлийг хангуулах талаар холбогдох байгууллагад чиглэл хүргүүлэх тухай саналыг уламжилж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Н.АЛДАРБАЯР ТАНАА:

1. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 “Аймаг, ,,,,,,, ИТХ нь газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих”, 57.1 “Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд аймгийн ИТХ хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу төрийн хяналт тавина” гэсэн заалтын хүрээнд баталсан хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн хяналт шалгалтын тайланд хамрах хүрээ, авсан арга хэмжээг тодорхой дурдаж, үр дүнг нэгтгэн, жилийн үйл ажиллагааны тайланд тусгах, мөн газрын харилцааны чиглэлээр баталсан шийдвэрийн биелэлтийг хянахдаа сумдын жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт, аймаг, сумдын Засаг даргын газрын харилцааны асуудлаар гаргасан шийдвэр зэрэг холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тухайн жилийн бодит биелэлтийг хянаж үнэлэх.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. МУ-ын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын II хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын 3.1-т “УТХО-аар эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт болон малчдын хоршоонд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд зориулж газрыг төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлж, ашиглуулна” гэсэн заалтыг баримтлан, тухайн жилд зохион байгуулах газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг хуульд заасан зориулалтад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэх.
2. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т “Аймаг, сумын засаг дарга нь газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах” заалтын хүрээнд хуульд заасан хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэх тухай арга хэмжээг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой зорилт болгон тусгах, аймгийн хэмжээнд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн хяналт шалгалтын ажлын үр дүнг нэгтгэж, хэрэгжилтийг дүгнэж ажиллах.

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН ТАНАА:

1. Засгийн газрын 2022 оны 432 тогтоолын хавсралтаар батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх журам”-ын 2.2 “Аймгийн газрын асуудал эрхэлсэн байгууллага, сумын газрын даамал цахим системээр дамжуулан

газрын нэгдмэл сангийн тайлангийн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлнэ” гэсэн заалтын дагуу газар зохион байгуулалтын цахим системд тухайн жилийн газар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулахтай холбоотой өгөгдөл мэдээллийг бүрэн, үнэн зөв оруулах талаар холбогдох албан тушаалтнуудад чиглэл өгч, хяналт хэрэгжүүлэн, аймгийн газрын нэгдмэл сангийн тайлангийн үнэн зөв илэрхийлэгдэх нөхцөлийг хангаж ажиллах.

2. Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.5 “*Аймаг, нийслэлийн газрын алба нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлыг зохион байгуулах эрх хэмжээтэй байна*” гэсэн чиг үүргийн хүрээнд газрыг хүндэтгэх шалтгаангүй 2 жил дараалан ашиглаагүй зөрчлийг арилгахад улсын байцаагчийн хэрэгжүүлэх хяналт шалгалтыг чиглүүлэн, тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, ашиглалтгүй газрыг дахин төлөвлөлтөд оруулж эзэмшүүлэх.

СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА НАРТ:

1. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 “*Сумын ИТХ нь газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих*”, 57.1 “*Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд ,,,,,,, сумын ИТХ хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу төрийн хяналт тавина*” гэсэн заалтын хүрээнд газар эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, мөн газрын харилцааны чиглэлээр баталсан шийдвэрийн биелэлтийг хянахдаа сумын Засаг даргын газар эзэмшүүлж, ашиглуулах тухай шийдвэрийн үндэслэл, төлөвлөгөөтэй уялдсан байдал зэрэг бодит нөхцөл байдлыг үнэлж дүгнэх.

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. ГХБГЗЗГ-ын даргын 2010 оны 497 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-д тусгасан хугацаанд ажлын хэсгийг томилох, тухайн жилийн төлөвлөгөөний төслийг аргачлалд тусгасан зарчим, боловсруулах, дараалал, шийдвэрлэх асуудлыг бүрэн хамруулан боловсруулж, сумын ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулах.
2. Газрын тухай хуулийн 56.1 “*Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ*” гэсэн заалтын хүрээнд хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулж мөрдөх.
3. Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 “*Аймаг, сум, нийслэлийн Засаг дарга хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно*”, 57.1 “*Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд сумын Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу*

хяналт тавина” гэсэн заалтын хүрээнд 2 жил дараалан ашиглалтгүй байгаа газрын судалгааг нэгтгэн гаргаж, эзэмших эрхийг цуцлах, Газрын тухай хуульд заасан газрын талаар төрийн баримтлах тэгш байдлыг хангах зарчмын хүрээнд тус газрыг сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгаж, дахин хуваарилах арга хэмжээ авах.

4. Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т *“Аймаг, сумын засаг дарга нь газар эзэмшигч, ашиглагчаас газар, түүний баялгийг хууль тогтоомж, гэрээний дагуу үр ашигтай, зохистой ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах”*, заалтын хүрээнд сумын хэмжээнд хууль тогтоомж, Засгийн газар, дээд шатны Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх хяналт тавих ажлыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухайлсан арга хэмжээ болгож тусгах, хэрэгжилт, үр дүнг нэгтгэж, хэмжигдэхүйц тодорхой үзүүлэлтээр тайлагнах.

МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

1. Газрын тухай хуулийн 20.2.1 *“Аймаг, сумын Засаг дарга газрын харилцааны талаар нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”* гэсэн заалтын дагуу сумын ИТХ-аас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль, тогтоомжид заасан эрхийн хүрээнд шийдвэрлэх.

ЗАМЫН-ҮҮД, САЙНШАНД, ХАТАНБУЛАГ, СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 *“Эзэмшил газрын хэмжээ, байршлыг 29.10.1-29.10.8-д заасан тохиолдолд өөрчилж болно”* гэсэн заалтын хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан эзэмшил газрын байршил өөрчлөх хүсэлтийг хууль, журамд заасан шаардлага, нөхцөлийг хангасан байдлыг харгалзан үзэж шийдвэрлэх.

ДАЛАНЖАРГАЛАН, ЗАМЫН-ҮҮД, ХАТАНБУЛАГ СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4 *“Баримт бичгийг мэдээллийн эх сурвалж, хуулийн хүчинтэй байх шаардлагад нийцүүлэн зохиож хөтлөх”* гэсэн заалтын дагуу газрын харилцааны талаар шийдвэр батлахдаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журмын, холбоотой заалтыг үндэслэж, эрх зүйн үндэслэлтэй шийдвэр төлөвлөж, батлах.